



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 16-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/47/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 30
танай _____-ны № _____-т

16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БУЯНДЭЛГЭР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 16 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

16 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57 597 561,57	62 911 283,57
33	АВЛАГА	1 950 441,57	1 950 441,57
335	Бусад авлага	1 950 441,57	1 950 441,57
3351	Байгууллагаас авах авлага	1 852 441,57	1 852 441,57
3352	Хувь хүмүүсээс авах авлага	98 000,00	98 000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	55 647 120,00	60 960 842,00
351	Түүхий эд материал	51 338 270,00	51 773 760,00
35110	Тусгай зориулалттай материал	51 338 270,00	51 773 760,00
354	Хангамжийн материал	4 308 850,00	9 187 082,00
35410	Бичиг хэргийн материал	444 600,00	183 000,00
35420	Аж ахуйн материал	1 819 800,00	877 260,00
35450	Барилгын засварын материал	-	7 890 050,00
35460	Хүнсний материал	2 044 450,00	236 772,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1 510 126 955,65	1 468 664 796,53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 510 126 955,65	1 468 664 796,53
392	Биет хөрөнгө	1 296 806 955,57	1 255 444 796,41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 332 411 570,18	1 332 411 570,18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59 133 186,26)	(96 905 147,66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50 236 081,00	53 101 581,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41 618 932,74)	(43 793 782,94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57 511 989,80	57 511 989,80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42 600 566,41)	(46 881 413,97)
393	Биет бус хөрөнгө	213 320 000,08	213 220 000,12
39301	Програм хангамж	990 000,00	990 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(789 999,92)	(889 999,88)
39303	Бусад биет бус хөрөнгө	213 120 000,00	213 120 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1 567 724 517,22	1 531 576 080,10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	107 051,55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	107 051,55
413	Өглөг	-	107 051,55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	107 051,55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1 567 724 517,22	1 531 469 028,55
51	Засгийн газрын хувь оролцоо	1 567 724 517,22	1 531 469 028,55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	428 794 669,00	428 794 669,00
512	Хуримтлагдсан үр дүн	(119 089 713,14)	(155 345 201,81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(119 089 713,14)	(119 089 713,14)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36 255 488,67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 258 019 561,36	1 258 019 561,36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 567 724 517,22	1 531 576 080,10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	515 568 358,00	425 273 600,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104 185 658,00	3 964 100,00
120	Нийтлэг татварын бус орлого	104 185 658,00	3 964 100,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104 185 658,00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	104 185 658,00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2 865 500,00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		1 098 600,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	411 382 700,00	421 309 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373 517 100,00	371 900 500,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373 517 100,00	371 900 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	495 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	245 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37 865 600,00	48 914 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37 865 600,00	48 914 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	454 226 556,97	461 529 088,67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454 226 556,97	461 529 088,67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439 306 511,74	448 191 065,37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301 703 600,00	312 125 726,00
210101	Үндсэн цалин	185 361 013,76	311 392 526,00
210102	Нэмэгдэл	90 184 763,05	628 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1 205 573,52	104 400,00
210104	Урамшуулал	24 952 249,67	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 152 524,99	40 796 825,55
210201	Тэтгэврийн даатгал	25 753 815,45	28 542 703,12
210202	Тэтгэмжийн даатгал	3 903 799,42	3 111 987,32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 433 773,96	2 476 149,89
210204	Ажилгүйдлийн даатгал	544 485,32	604 824,02
210205	Эрүүл мэндийн даатгал	5 516 650,84	6 061 161,20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23 226 591,78	23 489 446,70
210301	Гэрэл, цахилгаан	2 871 255,10	4 485 334,17
210302	Түлш, халаалт	12 498 805,72	13 383 149,84
210303	Цэвэр, бохир ус	7 856 530,96	5 620 962,69
2104	Хангамж, бараа материалын зардал	10 384 060,00	4 841 290,00
210401	Бичиг хэрэг	173 700,00	882 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	169 100,00	228 050,00

210404	Ном, хэвлэл	60 500,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5 344 760,00	980 540,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 620 000,00	2 750 100,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	16 000,00	-
2105	Нормативт зардал	21 870 348,00	15 628 738,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150 598,00	45 400,00
210502	Хоол, хүнс	21 719 750,00	15 583 338,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4 300 380,00
210604	Урсгал засвар	-	4 300 380,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 018 000,00	1 333 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10 000,00	325 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 008 000,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42 951 386,97	45 675 659,12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176 600,00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 452 800,00	1 348 000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38 321 986,97	44 327 659,12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14 920 045,23	13 338 023,30
2132	Бусад урсгал шилжүүлэг	200 000,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14 639 008,22	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14 639 008,22	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81 037,01	13 338 023,30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81 037,01	13 338 023,30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	61 341 801,03	(36 255 488.67)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2 330 450,00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2 330 450,00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2 330 450,00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	59 011 351,03	(36 255 488.67)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцоо
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	428 794 669,00	1 258 019 561,36	(119 089 713,14)	1 567 724 517,22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-

Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(36 255 488,67)	(36 255 488,67)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	428 794 669,00	1 258 019 561,36	(155 345 201,81)	1 531 469 028,55

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	412 817 527,00	421 309 500,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412 817 527,00	421 309 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	373 517 100,00	371 900 500,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373 517 100,00	371 900 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	495 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	245 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37 865 600,00	48 914 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37 865 600,00	48 914 000,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1 434 827,00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1 434 827,00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	412 817 527,00	421 309 500,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412 817 527,00	421 309 500,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396 462 654,77	407 971 476,70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301 703 600,00	311 604 700,00
210101	Үндсэн цалин	185 361 013,76	200 830 511,36
210102	Нэмэгдэл	90 184 763,05	85 811 855,97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1 205 573,52	728 800,00
210104	Урамшуулал	24 952 249,67	24 233 532,67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 152 524,99	41 210 800,00
210201	Тэтгэврийн даатгал	25 753 815,45	28 608 800,00
210202	Тэтгэмжийн даатгал	3 903 799,42	3 150 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 433 773,96	2 520 400,00
210204	Ажилгүйдлийн даатгал	544 485,32	630 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5 516 650,84	6 301 000,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23 226 591,78	23 489 446,70
210301	Гэрэл, цахилгаан	2 871 255,10	4 485 334,17
210302	Түлш, халаалт	12 498 805,72	13 383 149,84
210303	Цэвэр, бохир ус	7 856 530,96	5 620 962,69
2104	Хангамж, бараа материалын зардал	6 457 200,00	2 499 250,00
210401	Бичиг хэрэг	96 700,00	280 200,00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	169 100,00	228 050,00
210404	Ном, хэвлэл	60 500,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5 956 800,00	514 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	174 100,00	1 477 000,00
2105	Нормативт зардал	24 027 838,00	14 256 550,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150 598,00	45 400,00
210502	Хоол, хүнс	23 343 440,00	13 775 660,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533 800,00	435 490,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	12 190 430,00
210604	Урсгал засвар	-	12 190 430,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 018 000,00	1 333 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10 000,00	325 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 008 000,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 876 900,00	1 387 300,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176 600,00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 700 300,00	1 387 300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16 354 872,23	13 338 023,30
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 634 827,00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1 434 827,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14 639 008,22	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14 639 008,22	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81 037,01	13 338 023,30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81 037,01	13 338 023,30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	411314500,00	396391810,18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411314500,00	396391810,18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411314500,00	397976546,70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311604700,00	311604700,00
210101	Үндсэн цалин	171357800,00	200830511,36
210102	Нэмэгдэл	112496200,00	85811855,97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2535300,00	728800,00
210104	Урамшуулал	25215400,00	24233532,67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41210800,00	41210800,00
210201	Тэтгэврийн даатгал	28608800,00	28608800,00
210202	Тэтгэмжийн даатгал	3150500,00	3150500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2520400,00	2520400,00
210204	Ажилгүйдлийн даатгал	630100,00	630100,00

210205	Эрүүл мэндийн даатгал	6301000,00	6301000,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36723500,00	23489446,70
210301	Гэрэл, цахилгаан	4374500,00	4485334,17
210302	Түлш, халаалт	19943700,00	13383149,84
210303	Цэвэр, бохир ус	12405300,00	5620962,69
2104	Хангамж, бараа материалын зардал	2026500,00	2004250,00
210401	Бичиг хэрэг	78900,00	35200,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63 900,00	228 050,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	346 300,00	264 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 488 000,00	1 477 000,00
2105	Нормативт зардал	14 257 600,00	14 256 550,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45 400,00	45 400,00
210502	Хоол, хүнс	13 776 700,00	13 775 660,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	435 500,00	435 490,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 690 500,00	2 690 500,00
210604	Урсгал засвар	2 690 500,00	2 690 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 333 000,00	1 333 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	325 000,00	325 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 008 000,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 387 300,00	1 387 300,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 387 300,00	1 387 300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	(1 584 736,52)
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	(1 584 736,52)
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	(1 584 736,52)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	411 314 500,00	409 729 763,48
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	371 900 500,00	371 900 500,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371 900 500,00	371 900 500,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39 414 000,00	39 414 000,00
132001	Орон нутгийн төсвөөс	39 414 000,00	39 414 000,00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	(1 584 736,52)
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	(1 584 736,52)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9 994 930,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9 994 930,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9 994 930,00
2104	Хангамж, бараа материалын зардал	495 000,00
210401	Бичиг хэрэг	245 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9 499 930,00
210604	Урсгал засвар	9 499 930,00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,00

213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	70,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	495 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	495 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 16-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 16-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 16-р цэцэрлэг нь 140 хүүхдийн хүчин чадалтай, 6 бүлэгтэй, 28 багш ажиллагсадтайгаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд тухайн нас бүрт нь таарсан боловсрол, өөрийгөө илэрхийлэх арга барил, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлэх буюу СӨБ-ын үйл ажиллагааг явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 16-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 400,178.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,001.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,801.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 16-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,148.4 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,950.4	1,950.4	0.0
Бараа материал	55,647.1	60,960.8	5,313.7
Үндсэн хөрөнгө	1,510,126.9	1,468,664.8	(41,462.1)
Нийт хөрөнгө	1,567,724.5	1,531,576.1	(36,148.4)
Өр төлбөр	0.0	107.1	107.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,138,929.8	1,102,674.4	(36,255.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,034,321.3	1,977,449.1	(56,872.3)

Бараа материалын данс 60,960.8 мянган төгрөг болж 5,313.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн хөрөнгө оруулалтаар 9,500.0 мянган төгрөгийн засварын материал, БШУГ-ын сайдын А/266-р тушаалын дагуу эцэг эхчүүдээс 1,098.6 мянган төгрөгийн өртөг бүхий сургалт, ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг орлогодож, тайлант үеийн бараа материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,468,664.8 мянган төгрөг болж өмнөх оноос 41,462.1 мянган төгрөгөөр буурсан нь БШУГ-аас 2,865.0 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер тоног төхөөрөмж орлогдсон боловч үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээнээс шалтгаалж буурчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,102,674.4 мянган төгрөг болж өмнөх оноос 36,255.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 16-р цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397,533.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 397,533.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Үүнээс хөл хорионы үеийн хоолны зардлаас тодотгол хийж 25,632.5 мянган төгрөгөөр бууруулан 371,900.5 мянган төгрөгөөр батлуулсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 371,900.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 48,914.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нэмэлт санхүүжилтаар 495.0 мянган төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 396,391.8 мянган төгрөгийг зарцуулж, 13,338.0 мянган төгрөгийг мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 396,391.8 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,234.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУГ-аас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 250.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 245.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс бичиг хэргийн зардалд 245.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хувь хүний орлогын албан татварын тухай 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно.” гэсэн заалтыг баримталж ажиллаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

16-р цэцэрлэг нь 2021 онд 395,207.1 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 395,207.1 мянган төгрөгийн 145 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,918.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт, 4,578.7 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь

Албан шаардлага	1	4,587.7	1	4,587.7			
Зөвлөмж	2	4,918.7	2	4,918.7			
Нийт дүн	3	9,506.4	3	9,506.4			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,573.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээр, 1,573.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

Тайлант онд гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.3 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 5, 8 сарын худалдан авах ажиллагаатай холбоотой 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн мэдээлж байх.

2. Цалин, нэмэгдэл хөлстэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажилтан нарын цалингаас 1 368.6 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутган тооцсон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажилтны чадвар алдалтын хувь хэмжээ болон сунгалтын мэдээллийг авч, хууль тогтоомжийн дагуу цалингийн тооцооллыг хийх.

3. Авлага өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 98.0 мянган төгрөгийн авлага, 107.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант оны эцэст авлага өглөг үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 16-р цэцэрлэг	3	1,573.7							3	1,573.7
Нийт		3	1,573.7							3	1,573.7

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ийн ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

